

НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 14 өдөр

Дугаар

128/ШЗ2020/0442

Улаанбаатар хот

Захиргааны хэрэг үүсгэх тухай

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Г.Мөнхтулга би, Ардчилсан намаас Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газар, улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт тус тус холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг хүлээн авч хянаад,

ТОДОРХОЙЛОХ нь:

Ардчилсан намаас тус шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагадаа: "... Иргэн С.Эрдэнийн гаргасан хүсэлтийг үндэслэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналтын улсын байцаагч 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр "Тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгох тухай" 6030 дугаар дүгнэлт үйлдэн Ардчилсан намын 1117237845 хяналтын дугаар бүхий тамгыг хүчингүй болгож, улмаар улсын бүртгэгч 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр "Тамга, тэмдгийн хяналтын дугаарын улсын бүртгэлийн хуудас"-аар тамга, тэмдгийн хяналтын 9020120477 дугаар олгосон байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсэгт зааснаар тамга, тэмдэг устсан, түүнийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд л урьд олгогдсон тамга, тэмдэгийн хяналтын дугаарыг хяналтын улсын байцаагч хүчингүйд тооцох зохицуулалттай байна. Мөн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсэгт тамга, тэмдгийн хяналтын дугаарыг дахин олгох үндэслэлийг нэрлэн заасан бөгөөд үүнд, тамга, тэмдэг ашиглах боломжгүйгээр элэгдэж хуучирсан, гэмтсэн; тамга, тэмдгийн өнгө, загвар, хэлбэрийг өөрчлөх хүсэлт гаргасан; хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн хүрээнд гэрчилгээг дахин авах хүсэлт гаргасан; гэрчилгээ болон тамга, тэмдгийг хаяж үрэгдүүлсэн, гэрчилгээ болон тамга, тэмдэг устсан; улсын бүртгэлийг хүчингүйд тооцсоны улмаас гэрчилгээ болон тамга, тэмдгийг ашиглах боломжгүй болсон тохиолдолд тамга, тэмдэгийн хяналтын дугаарыг дахин олгохоор хуульчилжээ.

002007827

Ардчилсан намын зүгээс 1117237845 хяналтын дугаар бүхий тамгаа өөрийн амжилт, өмчлөлдөө байлган, намын өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж байгаа бөгөөд манай намаас тамгын 1117237845 хяналтын дугаараа хүчингүй болгуулах, дахин хяналтын дугаар авах талаар ямар нэгэн хусалт Улсын бүртгэлийн байгууллагад гаргаагүй болно.

Тодруулбал, Ардчилсан намын 17237843 хяналтын дугаар бүхий тамга устгаагүй, хаяж үрэгдээгүй, тамгын өнгө загвар өөрчлөгдөөгүй, тамгын хяналтын дугаар дахин авах хэрэгцээ, шаардлага үүсээгүй бөгөөд дээр дурдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8, 8.9-д заасан тамга, тэмдэгийн хяналтын дугаарыг хүчингүйд тооцож, хяналтын дугаар дахин олгох нөхцөл байдал огт байгаагүй юм.

Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг " дараах нөхцөлд захиргааны акт хууль бус болно", 47.1.6-д "иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байхгүй" гэж заасны дагуу Ардчилсан намын тамгын 1117237845 хяналтын дугаарыг хүчингүй болгох, дахин дугаар олгосон захиргааны актууд илт хууль бус гэж үзэж байна.

Ардчилсан намын эрх барих дээд байгууллага болох Үндэсний бодлогын хорооны 2020 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны 16/08 дугаар тогтоолоор Ардчилсан намын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Цэвэгдоржийн Туваан томилогдож, намын удирдлагатай холбоотой уг өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын дээд шүүх 2020 оны дүгээр сарын 05-ны өдөр бүртгэж, албаны веб /www.supremecourt.mn/ хуудсандаа холбогдох тогтоол, шийдвэрээ байршуулан, нийтэд мэдээлсэн байдаг.

Иргэн С.Эрдэнэ "намын тамгын хяналтын дугаарыг хүчингүй болгуулан, дахин шинээр хяналтын дагуу бүхий тамгыг өөртөө авах" замаар Ардчилсан намын удирдлагын эрх мэдлийг Улс төрийн намын тухай хууль, Ардчилсан намын дүрэмд зааснаас гадуур хууль бус аргаар олж авах оролдлогыг Улсын бүртгэлийн байгууллагатай хамтран хийж байгааг Ардчилсан нам мэдсэн даруйдаа хариуцагч захиргааны байгууллагад "намыг иргэн С.Эрдэнэ төлөөлөх эрхгүй болохыг, намын 1117237845 хяналтын дугаар бүхий тамга хэвийн хэрэглэгдэж байгаа талаар" мэдэгдэн холбогдох нотлох баримтуудыг хүргүүлсээр байсан. Гэтэл Ардчилсан намыг төлөөлөх эрхгүй этгээд /иргэн С.Эрдэнэ/-ийн хүсэлтээр, Ардчилсан намын тамгын 1117237845 хяналтын дугаарыг хүчингүйд тооцон, тамга, тэмдгийн 9020120477 хяналтын дугаарыг иргэн С.Эрдэнэд олгосон нь Ардчилсан нам

1117237845 хяналтын дугаарыг хүчингүйд тооцон, тамга, тэмдгийн 9020120477 хяналтын дугаарыг иргэн С.Эрдэнэд олгосон нь Ардчилсан намны үйл ажиллагааг алдагдуулаад зогсохгүй, улс төрийн оролцоог хязгаарлан, илт гишүүдийн эвлэлдэн нэгдэх эрхийг ноцтойгоор зөрчсөн, хууль бус үйл ажиллагаа боллоо.

Иймээс, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын улсын байцаагчийн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 6030 дугаар "Тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгох тухай" дүгнэлт болон улсын бүртгэлийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Тамга, тэмдгийн хяналтын дугаарын улсын бүртгэлийн хуудас" -аар тамга, тэмдгийн 9020120477 хяналтын дугаарыг иргэн С.Эрдэнэд олгосон нь илт хууль бус болохыг тогтоож өгнө үү.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дугаар зүйлийн 17.1.6, Захиргааны ерөнхий хуулийн 93 дугаар зүйлийн 93.1-д заасны дагуу дээрх захиргааны актад холбогдуулан урьдчилан шийдвэрлэх журмаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргад гомдол гаргасан бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газар 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Б/190 дүгээр албан бичгээр "маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх нь зүйтэй" гэсэн хариуг өгсөн. Мөн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйл, 21 дүгээр зүйлд зааснаар улс төрийн намын дүрэм, мөрийн хөтөлбөр, гүйцэтгэх удирдлага, түүний өөрчлөлт зэрэг асуудлаар гаргасан шийдвэр Монгол Улсын хууль, тухайн намын дүрэмд нийцэж байгаа эсэх болон бусад бүртгэлтэй холбогдолтой асуудлыг хянах, бүртгэх чиг үүрэг бүхий Улсын Дээд шүүх 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр Ардчилсан намын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Ц.Тувааныг бүртгэсэн, уг бүртгэл хүчин төгөлдөр байгаа нь Улсын дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн Б/87 дугаар албан бичгээс тодорхой харагдах бөгөөд Ардчилсан намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн хувьд энэхүү нэхэмжлэлийг гаргаж байна" гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д "Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан

нээх ажиллагааны дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон ажиллагааг зохицуулахад оршино" гэж заасан.

Хуулийн дээрх зохицуулалтын дагуу захиргааны хэргийн шүүх нь хүн, хуулийн этгээдээс зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй гэж үзэж байгаа эрх, түүль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, сэргээн тогтоолгохоор захиргааны байгууллагын хууль бус шийдвэр, үйл ажиллагаанд холбогдуулан гаргасан нэхэмжлэл нь мөн хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д заасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байхгүй тохиолдолд захиргааны хэрэг үүсгэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "Нэхэмжлэл" гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг", 17 дугаар зүйлийн 17.3-т "Энэ хуулийн 3.1.3-т заасан нэхэмжлэлийг гаргасан этгээдийг нэхэмжлэгч гэнэ" гэж тус тус заажээ.

Нэхэмжлэгчээс шүүхэд ирүүлсэн нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримтаас үзэхэд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3 дахь хэсэгт заасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байхгүй, Ардчилсан намын үндсэн дүрмийн 5.17.6-д "Намын Даргыг дараах үндэслэлээр УЕХ-ын хурлаар чөлөөлж намын Их хурлыг зарлана. Энэ тохиолдолд намын дараагийн Дарга сонгогдох хүртэл Намын Даргын эрх, үүрэг аль нэг дэд даргад шилжэнэ". Монгол Улсын Дээд шүүхийн 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 5/5051, 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 5/87 дугаар албан бичгүүдээр "Ардчилсан намын даргын үүрэг гүйцэтгэгчээр Ц.Туваан бүртгэгдсэн" гэх нөхцөл байдал тус тус тогтоогдож байх тул Ардчилсан намаас тус шүүхэд хандан гаргасан "...Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын улсын байцаагчийн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн "Тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгох тухай" 6030 дугаар дүгнэлт болон улсын бүртгэгчийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Тамга, тэмдгийн хяналтын дугаарын улсын бүртгэлийн хуудас"-аар тамга, тэмдгийн 9020120477 хяналтын дугаар дахин олгосон шийдвэрийг тус тус хууль бус болохыг тогтоолгох"

5
Улаанбаатар бүхий нэхэмжлэлийг хүлээн авч захиргааны хэрэг үүсгэх үндэслэлтэй

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1, 111.2-д заасныг удирдлага болгон ЗАХИРАМДЖЛАХ нь:
1. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-т заасныг үндэслэн "...Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын улсын байцаагчийн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгох тухай" 6030 дугаар дүгнэлт болон улсын бүртгэчийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Тамга, тэмдгийн хяналтын дугаарын улсын бүртгэлийн хуудас"-аар тамга, тэмдгийн 3020120477 хяналтын дугаар дахин олгосон шийдвэрийг тус тус хууль бус болохыг тогтоолох" тухай шаардлага бүхий Ардчилсан намын нэхэмжлэлээр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт тус тус холбогдуулан захиргааны хэрэг үүсгэсүгэй.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасныг үндэслэн Ардчилсан намын нэхэмжлэлтэй, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт холбогдох захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн С.Эрдэнийг бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр татан оролцуулсугай.

3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д заасныг үндэслэн нэхэмжлэлийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт тус тус гардуулж, хариу тайлбар ирүүлэх, үндэслэж буй нотлох баримтаа өөрөө шүүхэд гаргаж өгөх буюу шүүхийн шаардсанаар гаргаж өгөх болон хуульд заасан бусад эрх, үүргийг танилцуулж, хэрэгт ач холбогдох бүхий нотлох баримтыг цуглуулах, шаардлагатай бусад ажиллагаа явуулахыг шүүгчийн туслах Э.Ундралмаад даалгасугай.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.2-г зааснаар энэхүү захирамжид гэмдөл гаргах эрхгүй.

ШҮҮГЧ



Г.МӨНХТУЛГА